



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Танилт, нэвтрэлтийн арга,  
хэрэгсэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх үед хүн, хуулийн этгээдийг таньж, баталгаажуулахад ашиглах танилт, нэвтрэлтийн арга”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх үед хүн, хуулийн этгээдийг таних хэрэгсэл”-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД

ШТА1206 9023100394 5498449

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ц.БААТАРХҮҮ

Засгийн газрын 2024 оны 12 дугаар  
сарын 18-ны өдрийн 217 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

ШТА1206 0923100394 5409449

ТӨРӨӨС ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЦАХИМ ХЭЛБӨРЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭХ ҮЕД ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТАНЬЖ, БАТАЛГААЖУУЛАХАД  
АШИГЛАХ ТАНИЛТ, НЭВТРЭЛТИЙН АРГА

№	Үйлчилгээ авагч	Таних арга	Ашиглах өгөгдөл
1.	Иргэн	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд заасан Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, эсхүл “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн мэдээлэлтэй тулгах	Регистрийн дугаар, иргэний бүртгэлийн дугаар, биометрик өгөгдөл, гадаад паспортын дугаар, татвар төлөгчийн дугаар
2.	16 нас хүрээгүй хүүхэд	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд заасан Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулгах	Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийн регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаар
3.	Хуулийн этгээд	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заасан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сан, эсхүл “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн мэдээлэлтэй тулгах	Регистрийн дугаар, татвар төлөгчийн дугаар
4.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.6 дахь хэсэгт заасан мэдээллийн сантай тулгах	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэлийн дугаар

----оо----

Засгийн газрын 2024 оны 12 дугаар  
сарын 18-ны өдрийн 217 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРӨӨС ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭХ ҮЕД ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТАНИХ ХЭРЭГСЭЛ**

№	Таних хэрэгсэл	Хийх үйлдэл	Хандах мэдээллийн ангилал	Хандах мэдээллийн сангийн төрөл
1.	Тоон гарын үсэг	Танилт, нэвтрэлт, баталгаажуулалт	Хязгаарлалттай, хаалттай мэдээлэл	Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, байгууллагын мэдээллийн сан
2.	Биометрик өгөгдөл	Танилт, нэвтрэлт, баталгаажуулалт	Хязгаарлалттай, хаалттай мэдээлэл	Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, байгууллагын мэдээллийн сан
3.	Бүртгэлтэй гар утасны дугаар ашиглан нэг удаагийн нууц үгээр	Танилт, нэвтрэлт	Хязгаарлалттай, нээлттэй мэдээлэл	Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, байгууллагын мэдээллийн сан
4.	Банк, банк бус санхүүгийн байгууллагын баталгаажсан эрх ашиглан нэг удаагийн нууц үгээр	Танилт, нэвтрэлт	Хязгаарлалттай мэдээлэл	Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан
5.	Цахим шуудангийн хаяг	Танилт, нэвтрэлт	Хязгаарлалттай, нээлттэй мэдээлэл	Төрөлжсөн мэдээллийн сан болон байгууллагын мэдээллийн сан
6.	Нэвтрэх нэр, нууц үг	Танилт, нэвтрэлт	Хязгаарлалттай, нээлттэй мэдээлэл	Төрөлжсөн мэдээллийн сан болон байгууллагын мэдээллийн сан